

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны дүгээр сарын
...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧИЙГ ТОРГОХ ШИЙТГЭЛ, АЛДАНГИАС НЭГ УДАА ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн Монгол Улсын Засгийн газраас тогтоосон өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцалсан өдөр хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хугацаандаа ирүүлсэн боловч нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлөөгүй ажил олгогч, даатгуулагчийг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дахь зүйлийн 3-т заасан торгох шийтгэл, болон уг зүйлийн тайлбарын хоёр дахь өгүүлбэрт заасан хугацаандаа төлөөгүй шимтгэлд ногдуулах алдангиас тус тус чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Т

ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг
торгох шийтгэл, алдангиас нэг удаа чөлөөлөх тухай
хуулийн төсөл*

Дэлхийн 160 гаруй улсад тархаад байгаа шинэ коронавируст халдварын дэгдэлтийн улмаас 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 179 800 хүн өвчний халдвар авч, 7 076 хүн нас бараад байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоолоор шинэ коронавируст халдвараас урьдчилан дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 02 сарын 13-ны өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн бөгөөд тус хугацааг Засгийн газрын 2020 оны 64 дүгээр тогтоолоор 2020 оны 03 сарын 30-ны өдөр хүртэл үргэлжлэхээр сунгасан байна.

Дээрх тогтоолтой холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагыг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулах, ресторан, нийтийн хоолны болон үзвэр, үйлчилгээний байгууллага, иргэдийн бизнесийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүний улмаас зарим аж ахуйн нэгж, байгууллагын болон иргэдийн бизнесийн үйл ажиллагаа доголдож, орлого буурснаар нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлж чадахгүй нөхцөл үүсэж байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлөөгүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, мөн шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алданги тооцохоор Зөрчлийн тухай хуульд заасан нь шинэ коронавирусын тархалт, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалж санхүүгийн хямралд ороод байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнд ихээхэн хэмжээний дарамт нэмэхээр байна.

Иймд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаа үнэн, зөв гаргаж, нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлсэн боловч улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хамаарах нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй, эсхүл дутуу төлсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Зөрчлийн тухай хуульд заасан дээрх торгох шийтгэл, алдангийг ногдуулахгүй байх эрх зүйн зохицуулалт шаардлагатай байгаа тул Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас нэг удаа чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулав.

Энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлснээр 6 мянга орчим ажил олгогчид 11.6 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг хугацаанд нь төлөөгүйд ногдуулах торгууль, алдангиас чөлөөлдөх урьдчилсан тооцоо, судалгаа байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль холбогдох бусад хуультай нийцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ